



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 989

Хархорин сум

Газар эзэмших эрхийн  
гэрчилгээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2-р багийн нутаг дэвсгэр Мойлт 1-23 тоотод Гэр орон сууц, хашааны зориулалтаар эзэмшиж байгаа Э.Ганбатын 6209000389 нэгж талбарын дугаартай 822 м<sup>2</sup> газрын эзэмших эрхийн гэрчилгээгийн хугацааг 60 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Газар эзэмшигч (Э.Ганбат)-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг иргэн (Э.Ганбат)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2003 оны А/22 дугаар захирамжийн (Э.Ганбат)-д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Г.ОДГЭРЭЛ

401100177